



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021-/20/-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал

Утас:70350757

Цахим хаяг: ajzargalb@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
4. Менежментийн захидал.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 30  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МЭДЭЭЛЭЛ ШУУРХАЙ  
УДИРДЛАГЫН ТӨВИЙН ДАРГА  
Н.ГАНСҮХ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>909,350.00</u>	<u>22,662,236.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	909,350.00	22,662,236.00
351	Түүхий эд материал	740,850.00	22,418,236.00
35110	Тусгай зориулалттай материал	740,850.00	22,418,236.00
354	Хангамжийн материал	168,500.00	244,000.00
35410	Бичиг хэргийн материал	-	44,000.00
35420	Аж ахуйн материал	168,500.00	-
35440	Түлш, шатах тослох материал	-	200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>937,857,765.22</u>	<u>1,207,802,230.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	937,857,765.22	1,207,802,230.11
392	Биет хөрөнгө	855,631,098.54	1,079,725,965.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,900,000.00	5,900,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,333.32)	(393,333.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	754,039,621.00	1,165,859,759.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,301,219.16)	(209,798,027.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,947,392.00	27,867,392.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(870,246.34)	(3,493,652.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	122,090,570.00	122,090,570.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,076,685.64)	(28,306,742.56)
393	Биет бус хөрөнгө	82,226,666.68	128,076,264.72
39301	Програм хангамж	88,100,000.00	88,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,873,333.32)	(23,493,333.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	67,069,598.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,600,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>938,767,115.22</u>	<u>1,230,464,466.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>900,000.00</u>	<u>-</u>

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	900,000.00	-
413	Өглөг	900,000.00	-
4136	Бусад өглөг	900,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	900,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	937,867,115.22	1,230,464,466.11
51	Засгийн газрын хувь оролцоо	937,867,115.22	1,230,464,466.11
512	Хуримтлагдсан үр дүн	937,867,115.22	1,230,464,466.11
51210	Өмнөх үеийн үр дүн	937,867,115.22	937,867,115.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	292,597,350.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	938,767,115.22	1,230,464,466.11

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	661,946,971.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	502,585,722.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	502,585,722.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	502,585,722.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	502,585,722.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	159,361,249.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,374,949.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,374,949.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	147,986,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	147,986,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	369,349,620.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	369,349,620.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	334,925,370.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	88,912,654.00
210101	Үндсэн цалин	-	88,912,654.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	10,866,772.56
210201	Тэтгэврийн даатгал	-	7,557,575.72
210202	Тэтгэмжийн даатгал	-	889,126.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	671,743.82
210204	Ажилгүйдлийн даатгал	-	159,108.35
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,589,218.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	10,522,572.47
210301	Гэрэл, цахилгаан	-	8,854,095.25
210302	Түлш, халаалт	-	1,222,060.41
210303	Цэвэр, бохир ус	-	446,416.81
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,267,300.00

**Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	-	689,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,131,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,485,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
210604	Урсгал засвар	-	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	190,800.00
210702	Дотоод албан томилолт	-	190,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	212,865,271.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	212,865,271.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	34,424,249.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	33,424,249.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,424,249.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	292,597,350.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	292,597,350.89

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	164,764,049.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	164,764,049.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	11,374,949.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,374,949.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	147,986,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	147,986,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	5,402,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	5,402,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	164,764,049.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	164,764,049.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	124,936,999.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	88,912,654.00
210101	Үндсэн цалин	-	84,136,980.00
210102	Нэмэгдэл	-	4,775,674.00

**Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	10,866,772.56
210201	Тэтгэврийн даатгал	-	7,557,575.72
210202	Тэтгэмжийн даатгал	-	889,126.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	671,743.82
210204	Ажилгүйдлийн даатгал	-	159,108.35
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,589,218.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	10,522,572.47
210301	Гэрэл, цахилгаан	-	8,854,095.25
210302	Түлш, халаалт	-	1,222,060.41
210303	Цэвэр, бохир ус	-	446,416.81
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,342,800.00
210401	Бичиг хэрэг	-	733,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,131,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,317,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,801,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,200,000.00
210604	Урсгал засвар	-	6,601,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	190,800.00
210702	Дотоод албан томилолт	-	190,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	39,827,049.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,402,800.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	5,402,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	33,424,249.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,424,249.97

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	937,867,115.22	937,867,115.22
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	937,867,115.22	937,867,115.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	937,867,115.22	937,867,115.22
D08	Тайлант үеийн үр дүн	292,597,350.89	292,597,350.89
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,230,464,466.11	1,230,464,466.11

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	147,986,300.00	114,562,050.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,986,300.00	114,562,050.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,986,300.00	113,562,050.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,669,500.00	84,669,500.00
210101	Үндсэн цалин	76,972,300.00	79,893,826.00
210102	Нэмэгдэл	7,697,200.00	4,775,674.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,583,700.00	10,336,377.56
210201	Тэтгэврийн даатгал	7,196,900.00	7,196,907.12
210202	Тэтгэмжийн даатгал	846,700.00	846,694.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	677,400.00	637,798.54
210204	Ажилгүйдлийн даатгал	169,300.00	150,622.03
210205	Эрүүл мэндийн даатгал	1,693,400.00	1,504,354.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,492,300.00	10,522,572.47
210301	Гэрэл, цахилгаан	35,000,000.00	8,854,095.25
210302	Түлш, халаалт	4,961,900.00	1,222,060.41
210303	Цэвэр, бохир ус	2,530,400.00	446,416.81
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	6,540,800.00	6,342,800.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	733,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,610,800.00	3,131,900.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	870,000.00	1,317,200.00

**Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	190,800.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	190,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>147,986,300.00</b>	<b>147,986,300.00</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>147,986,300.00</b>	<b>147,986,300.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	147,986,300.00	147,986,300.00

## **2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Н.Гансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мэдээлэл шуурхай удирдлагын төв байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, ЦАГДАА, ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН НЭГДСЭН ДУУДЛАГА ҮЙЛЧИЛГЭЭГ НЭГ ЦЭГТ ТӨВЛӨРҮҮЛЖ ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ АШИГЛАН НЭГДСЭН УДИРДЛАГА, МЭДЭЭЛЭЛЭЭР ИРГЭДИЙГ НАЙДВАРТАЙ ХАНГАНА.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль.
- Засаг захиргаа түүний удирдлагын тухай хууль
- Хөдөлмөрийн дотоод дүрэм, журам
- Бусад хууль тогтоомж

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэдээлэл шуурхай удирдлагын төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлыг тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 232,799.2 мянган төгрөгийн 1 хувиар 2,328.0 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 661,946.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,619.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 291,697.3 мянган төгрөгөөр буюу 31 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,0	0,0	0,0

**Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Авлага	0,0	0,0	0,0
Урьдчилгаа	0,0	0,0	0,00
Бараа материал	909.35	22,662.24	21,752.89
Үндсэн хөрөнгө	937,857.77	1,207,802.23	269,944.46
<b>Нийт хөрөнгө</b>	<b>938,767.12</b>	<b>1,230,464.47</b>	<b>291,697.35</b>
Өр төлбөр	0,0	0,0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0,0	0,0	
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>938,767.12</b>	<b>1,230,464.47</b>	<b>291,697.35</b>

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 22,662.24 мянган төгрөг болж 21,752.89 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын материал /Орон нутгийн хөрөнгө оруулалтаар/ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,207,802.23 мянган төгрөг болж 269,944.46 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үндсэн хөрөнгө /хотын камержуулалттай холбоотой/-үүд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2019 оны 09 сард үүсэн байгуулагдсан бөгөөд 2020 оны үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 147,986.3 мянган төгрөгөөр баталж, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх 147,986.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 147,986.3 мянган төгрөгийн санхүүжилтыг авч, урсгал үйл ажиллагааны зардалд 114,562.05 мянган төгрөгийг зарцуулж 33,424.25 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс харахад төсвийн төлөвлөлт хангалтгүй бодитой бус байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого**

Мэдээлэл шуурхай удирдлагын төв нь орон нутгийн төсөвт орлого төвлөрүүлдэггүй болно.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансандаа камерын засвар үйлчилгээний зардалд 5,000.0 мянга, ЗД-ын нөөц сангаас 1,601.4 мянган төгрөг мөн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн АӨЗ-аас нягтлан бодогчийн цалин хөлс 4,243.15 төгрөг ажил олгогчоос төлөх НДШ-ийн 530.39 төгрөгийн нийт 11,374.95 мянган төгрөгийн орлого орж, мөн нийт 11,374.95 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Мэдээлэл шуурхай удирдлагын төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, 1 акт өгсөнөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1		1				
Зөвлөмж	4		4				
Нийт дүн	5		5				

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,290.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 190.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 1,100.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 он санхүүгийн тайлангаар ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 190.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрсэнээс 190.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо Үүнд: Байгууллагын даргын 2019 оны томилолтын зардлыг тухайн оны санхүүгийн тайландаа өглөгөөр тусгаагүй бөгөөд 2020 оны батлагдсан төсвөөс нөхөн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.1-д “төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.6-д “төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, НББ-ийн тухай хуулийн 13.1-д “Анхан

шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1,100.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, хөрөнгийн тооллого хийх шаардлагатай гэж үзлээ.

### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажуулж, баримтаар 1,100.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

**Эрсдэл:** Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх

**Өгсөн зөвлөмж:** Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулж, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

1.2. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 18 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **ТАЙЛАН БИЧСЭН:**

Бэлтгэсэн: Аудитор	Б.Азжаргал	Огноо
Анхан шатанд хянасан: Аудитын менежер	Б.Эрдэнэ	Огноо
Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор	Ц.Нармандах	Огноо

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Эрсдэл:** Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх

**Өгсөн зөвлөмж:** Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулж, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

1.2. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 18 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Б.Азжаргал

Огноо

Б.Эрдэнэ

Огноо

Ц.Нармандах

Огноо



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.2.25</b>	Аудитын нэр:	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ОРА-2021/20/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Мэдээлэл шуурхай удирдлагын төв</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажаагүй, баримтаар шатахуун зарцуулсан байна.	1,100.0	Зөвлөмж	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, нягтлан бодогч	Н.Гансүх Я.Ариунаа
2	Байгууллагын даргын 2019 оны томилолтын зардлыг тухайн оны санхүүгийн тайландаа өглөгөөр тусгаагүй бөгөөд 2020 оны батлагдсан төсвөөс нөхөн олгосон байна.	190.8	Төлбөрийн акт	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, нягтлан бодогч	Н.Гансүх Я.Ариунаа
<b>ДҮН</b>		<b>1,290.8</b>			

Бэлтгэсэн: Аудитор

Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах Огноо

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2021.2.25	Аудитын нэр: Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ОРА-2021/20/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Мэдээлэл шуурхай удирдлагын төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажуагүй, баримтаар шатахуун зарцуулсан байна.	1,100.0	Зөвлөмж	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, нягтлан бодогч	Н.Гансүх Я.Ариунаа
2	Байгууллагын даргын 2019 оны томилолтын зардлыг тухайн оны санхүүгийн тайландаа өглөгөөр тусгаагүй бөгөөд 2020 оны батлагдсан төсвөөс нөхөн олгосон байна.	190.8	Төлбөрийн акт	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга, нягтлан бодогч	Н.Гансүх Я.Ариунаа
<b>ДҮН</b>		<b>1,290.8</b>			

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүдэх аудитор

Б.Азжаргал Огноо 5/19

Б.Эрдэнэ Огноо

Ц.Нармандах Огноо





ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 26/26 ОАА-2021/01/СТА-БҮГ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2019 онд олгох байсан 190.8 мянган төгрөгийн томилолтын зардлыг тухайн оны санхүүгийн тайландаа өглөгөөр тусгаагүй бөгөөд 2020 оны батлагдсан төсвөөс нөхөн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.1-д "төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.6-д "төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", НББ-ийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тус төвийн дарга Н.Гансүхэд илүү олгосон томилолтын зардал болох 190.8 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь **100210000988** тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга Н.Гансүх нягтлан бодогч Я.Ариунаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... Б.АЗЖАРГАЛ

БАТЛАВ.  
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР /Ц.НАРМАНДАХ/

/гарын үсгийн тайлал/

6117143690  
ФАА0073 9043606

Орхон аймаг

2021 оны 02 дугаар сарын 25

### МЭДЭГДЭЛ

Мэдээлэл шуурхай удирдлагын төв-д

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасны дагуу асуудлын бүртгэлд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоохоор тусгагдсан алдаа зөрчилд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн \_\_\_\_\_ цагт сонсох ажиллагааг биечлэн уулзах хэлбэрээр явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Аудитор \_\_\_\_\_ /Б.Азжаргал/

албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан:

Мэдээлэл/шуурхай удирдлагын төв Ер.ня-бо \_\_\_\_\_ /Я.Ариунаа/

албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: 2021.02.05

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ  
ТЭМДЭГЛЭЛ

№ 01

2021 оны 02-р сарын 19-ны өдөр

Орхон аймаг

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн ерөнхий нягтлан бодогчтой 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 10 цагт Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан өрөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр;

Албан тушаал, нэр;

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан: \_\_\_\_\_

\_\_\_\_\_ гарын үсэг \_\_\_\_\_

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг \_\_\_\_\_

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг "Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн ерөнхий нягтлан бодогчид танилцуулав.

Асуулт, хариулт: Асуудлын бүртгэлээр танилцуулсан акт тогтоох, албан шаардлага өгөх алдаа зөрчилтэй асуудалтай холбоотой санал тайлбар байна уу?

Асуудлуудтай танилцсан холбогдох санал, тайлбар байхгүй, цаашид анхаарч ажиллах болно.

\_\_\_\_ Сонсох ажиллагааг \_\_\_\_\_ 10:30 \_\_\_\_\_ цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: Аудитор

Орхон аймаг /Б.Азжаргал/

Оролцогч: Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга \_\_\_\_\_ /Н.Гансүх/

Ерөнхий нягтлан бодогч

\_\_\_\_\_ /Я.Ариуаа/

